

04



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 144

Номгон

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх  
сангийн дүрэм баталж, зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.10, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 16 дугаар зүйлийн 16.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх сангийн дүрэм”-ийг нэгдүгээр хавсралтаар, сангийн зөвлөлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сангийн дүрмийг олон нийтэд сурталчилж, ажиллах нөхцлийг бүрдүүлж хамтран ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Сангийн дүрмийн хэрэгжилтийг хангах талаар холбогдох арга хэмжээг авч, хэрэгжүүлэхийг Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга (цагдаагийн хошууч Г.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Наранбаатар)-т даалгасугай.


ДАРГА



Э.ЭНХБАТ

0121321

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 22-ны  
өдрийн 144 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



## МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ САНГИЙН ДҮРЭМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрэм нь мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх сан /цаашид сан гэх/-г бүрдүүлэх, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Сангийн үйл ажиллагаа нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

1.3. Аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл Санг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

### ХОЁР. САНГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Сан нь аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл /цаашид "Зохицуулах салбар зөвлөл" гэх/-ийн дэргэд ажиллана.

2.2. Сангийн удирдах байгууллага нь Сангийн зөвлөл байна. Сангийн зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, орон тооны бус гишүүдээс бүрдэнэ. Гишүүдийн тоо 5-9 гишүүнтэй байна.

2.3. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд Зохицуулах салбар зөвлөлийн дарга нь Сангийн зөвлөлийн дарга байна.

2.4. Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүдийг тухайн аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга томилно.

2.5. Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга эрхлэн гүйцэтгэнэ.

2.6. Сангийн зөвлөл дараах бүрэн эрхтэй байна:

2.6.1. Сангийн үйл ажиллагаа болон сангийн хөрөнгөөр санхүүжих арга хэмжээний жил, улирлын төлөвлөгөө, тэдгээрийн төсвийг хэлэлцэн батлах;

2.6.2. Сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулах;



2.6.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах талаар гаргасан санал, санаачилгыг дэмжиж, хөдөлгөөн өрнүүлэх;

2.6.4. Сангийн хөрөнгөөр санхүүжиж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн явц, үр дүнгийн тухай тайланг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.6.5. Сангийн зөвлөлийн дарга болон нарийн бичгийн дарга, гишүүдийн ажил, үүргийн хуваарийг батлах;

2.6.6. Сангийн улирал, жилийн ажлын тайланг хэлэлцэх.

2.6.7. Сангийг хөрөнгийг бүрдүүлэх үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах.

2.7. Сангийн зөвлөлийн дарга нь Сангийн үйл ажиллагааг удирдан зохицуулж, сангийн хөрөнгийг энэ журмын 2.6.1-д заасны дагуу баталсан төлөвлөгөөнд заасан арга хэмжээнд зарцуулна.

2.8. Сангийн зөвлөлийн дарга нь Сангийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл санхүүжилтийг нь зогсоож, Сангийн зөвлөлийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

2.9. Сангийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.10. Сангийн зөвлөл асуудлыг тухайн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж тогтоол гаргана. Сангийн зөвлөлийн тогтоолд зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.11. Сангийн зөвлөлийн хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтөлж, зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.12. Сангийн зөвлөл нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2.13. Тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар Санг ажиллах нөхцөлөөр хангана.

2.14. Сангийн хөрөнгийг банкинд тусгай дансанд байршуулна.

#### ГУРАВ. САНГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ

3.1. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх санд гадаад, дотоодын иргэд, байгууллагын тусламж, хандив, малын тоо, толгойн албан татварын 1 хувь болон хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

3.2. Сангийн мөнгөн гүйлгээнд аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд Зохицуулах салбар зөвлөлийн дарга /ГХУСАЗСЗ-ийн дарга/ 1 дүгээр

гарын үсэг, ажлын албаны нягтлан бодогч /ИТХ-ийн нягтлан/ 2 дугаар гарын үсэг зурна.

3.3. Сангийн хөрөнгийг дараахь үйл ажиллагаанд зарцуулна:

3.3.1. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг сурталчлах, тайлбарлан таниулах, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, арилгах;

3.3.2. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүсийг урамшуулах;

3.3.3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг шагнах, урамшуулах, дэмжих

3.3.4. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх нэгдсэн арга хэмжээ

3.3.7. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр явуулж байгаа бусад үйл ажиллагааны зардлыг сангаас санхүүжүүлнэ.

3.4. Сангийн хөрөнгийг энэ дүрмийг 3.3-т зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

#### ДӨРӨВ. САНГИЙН ТАЙЛАН, БУСАД ЗҮЙЛ

4.1. Сумын сангийн зөвлөл сангийн орлого, зарлагын тайлан мэдээг улирал бүрийн сүүлчийн сарын 25-ны дотор гаргаж, аймгийн ГХУСАЗСЗ-д ирүүлнэ.

4.2. Сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасан аудит хийж, дүгэлт гаргана.


4.3. Сумын Сангийн зөвлөл нь аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хагас, бүтэн жилээр үйл ажиллагаагаа тайлагнана.

4.4. Сангийн зөвлөл нь үйл ажиллагааныхаа тайланг энэ дүрмийн 4.3-т заасан байгууллагад тайлагнахаас гадна тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон тухайн орон нутгийн иргэдэд жил бүр мэдээлнэ.

4.5. Гадаад, дотоодын иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс Санд оруулсан тусламж, хандивын хөрөнгийн зарцуулалтын тайланг шаардлагатай бол тухайн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид хүргүүлж болно.

4.6. Сангийн удирдах зөвлөл нь иргэн, аж ахуй нэгж, албан байгууллага, сангийн гишүүдийн хэрэгжүүлэхээр ирүүлсэн төсөл хөтөлбөрийн ач холбогдол үр нөлөөг харгалзан шийдвэрлэнэ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 22-ны  
өдрийн 144 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ  
САНГИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга-Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга

Нарийн бичгийн дарга-Аймгийн Цагдаагийн газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн

Гишүүд: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Аймгийн Цагдаагийн газрын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн ахлах мөрдөгч

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_